



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Аудитын код: УАГ-НАГ-2020/01/-НА

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг
2020 оны 05 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020

Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Аудитор:

Б.Уранбилэг

Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог.....	4
Дүрслэлийн товъёог	4
Хавсралтын товъёог.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУД ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСТ БҮРЭН ХАМРАГДСАН БОЛОВЧ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН МЭДЭЭЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээллээ бүрэн байршуулаагүй байна.

1.2 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд самбарын мэдээллийг бүрэн байршуулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭЛД ХАМААРАХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД ХУУЛИЙГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БА ҮҮНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.

2.1 Хуулийн 3.1.3-т хамаарах байгууллага хуульд заасан мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн мэдээлээгүй байна.

2.2 Улс, орон нутгийн төсвөөр хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд хууль, журамд заасан мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

БҮЛЭГ 3. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНААС ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

3.1 Хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллагууд хяналт тавьж ажилласан боловч хангалтгүй байна.

3.2 Өмнө оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага бүрэн биелсэн байна.

ДҮГНЭЛТ:.....	29
ЗӨВЛӨМЖ:	30
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:.....	32
Саналд өгсөн тайлбар:.....	35
ХАВСРАЛТУУД:.....	37

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АШУИС	Анагаахын шинжлэх ухааны их сургууль
БТСГ	Биеийн тамир спортын газар
БОАЖГ	Байгал орчин, аялал жуулчлалын газар
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОН	Орон нутаг
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СШ	Сайншанд
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УТ	Улсын төсөв
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Хүснэгтийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сүүлийн 3 жилийн байдлаарх тоон үзүүлэлт	14
Хүснэгт 2	Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуульд заасан мэдээллийг мэдээлсэн байдал	17
Хүснэгт 3	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний судалгаа	18
Хүснэгт 4	Хуулийн 3.1.5-д хамаарах ААНБ-уудын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст холбогдох мэдээллийг мэдээлсэн байдал.	22
Хүснэгт 3	Сумдын ИТХ-ын хяналт хэрэгжүүлсэн талаарх тайлан ирүүлсэн байдал.	24
Хүснэгт 5	Зөвлөмжийн хэрэгжилт	27

Дүрслэлийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагын судалгаа	22

Графикын товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Сүүлийн 2 жилийн харьцуулалт, тоон үзүүлэлт	14

Хавсралтын товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Хуулийн 3.1.1-3.1.2-т заасан байгууллагуудын судалгаа	33
Хавсралт 2	Хуулийн 3.1.1-3.1.2-т заасан байгууллагуудын судалгаа	34
Хавсралт 3	Хуулийн 3.1.3-т заасан байгууллагуудын судалгаа	35
Хавсралт 4	Хуулийн 3.1.4-т заасан байгууллагуудын судалгаа	36
Хавсралт 5	Хуулийн 3.1.5-д заасан байгууллагуудын судалгаа	37

Зургийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1-3	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ мэдээлээгүй байгууллагууд;	8
Зураг 4-5	Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг pdf хөрвүүлээгүй байгууллагууд;	10
Зураг 6-8	Мэдээллийн самбар	15
Зураг 9-10	Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны шилэн дансны цахим хуудас эрхлэн хөтлөлтийн байдал	18
Зураг 11-13	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлсэн гүйцэтгэгч байгууллагуудын шилэн дансны цахим хуудаст эрх нээлгэсэн байдал	19
Зураг 14-16	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлсэн гүйцэтгэгч байгууллагуудын шилэн дансны цахим хуудаст эрх нээлгэсэн боловч эрхлэн хөтөлсөн эсэх	20
Зураг 17-22	Өөрийн цахим сайттай ч холбогдох мэдээллийг мэдээлээгүй ААНБ	21
Зураг 23-24	Хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагын шилэн дансны цахим хуудасны эрхлэн хөтлөлтийн байдал	22

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

**Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дэх заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

**Аудитын
зорилт**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 –т байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжүүлсэн эсэх;

**Аудитын
хамарсан
хүрээ**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5 дахь хэсэгт заасан төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2019 оны байдлаарх шилэн дансны нэгдсэн систем дэх мэдээллийн мэдээлсэн байдалд аудит хийж гүйцэтгэлээ. Аудитаар 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хамруулав.

**Аудитын арга
зүй, шалгуур
үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуй нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгаж, дүн шинжилгээ хийн, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, зэрэг арга зүйг ашиглан аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт гаргалаа.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-н хүртэлх хугацаанд гэрээт аудитор гүйцэтгэн, 04 дүгээр сарын 23-ны өдрөөс санхүүгийн аудитын албаны аудиторууд гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 15-нийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэн, дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Аудитын тайлан, судалгааг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУД ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСТ БҮРЭН ХАМРАГДСАН БОЛОВЧ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН МЭДЭЭЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээллээ бүрэн байршуулаагүй байна.

1.1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд тогтмол мэдээлэх мэдээллээс 15 хувийг огт мэдээлээгүй байна.

Дорноговь аймагт шилэн дансны нэгдсэн системд бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 188, төрийн өмчит үйлдвэрийн газар 3, хуулийн 3.1.5¹-д заасан үйлчилгээ үзүүлэгч нийт 9 (хувийн сургууль 1, цэцэрлэг 4, Өрхийн эрүүл мэндийн төв 4) байгууллага байна. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3²-т заасан 1 байгууллага тус аймагт үйл ажиллагаагаа явуулж байна. Хамрагдвал зохих нийт 201 байгууллагыг хамрууллаа.

Тайлант онд Мал эмнэлгийн газар, Замын-Үүд сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэг зэрэг байгууллагууд шилэн дансны нэгдсэн системд шинээр цахим хуудас нээсэн байна.

Аудитад хамрагдсан нийт 191 байгууллага Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан тогтмол мэдээлэх нийт 5730 мэдээллээс 3925 мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж, 605 мэдээллийг хугацаа хоцроож, 835 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан тухайн жилийн төсвийг 01 дүгээр сарын 10-ны дотор мэдээлэх нийт 191 байгууллагын 76 нь хугацаандаа мэдээлж, 108 нь хугацаа хоцроож мэдээлсэн бол 7 байгууллага тухайн жилийн төсвийг мэдээлээгүй. Тухайлбал:

Улсын төсвийн байгууллага

- Мал эмнэлгийн газар;
- Шүүхийн шинжилгээний алба;
- Эрүүл мэндийн газар.

ТЗШ-ийн байгууллага

- Алтанширээ сумын ЕБС;
- Алтанширээ Хүүхдийн цэцэрлэг;
- Алтанширээ сумын Соёлын төв;
- Зүүнбаян БТСТ.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Нийгмийн даатгалын сан, Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаа, Сайншанд сумын Хүүхдийн 10 дугаар цэцэрлэг, Сайншанд сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг зэрэг байгууллагууд батлагдсан төсвийг мэдээлэхдээ холбогдох журмын дагуу хүснэгтээр мэдээлээгүй, pdf хувилбараар оруулсан нь мэдээлэл авахад энгийн, хялбар биш болгож байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 10-ны дотор мэдээлэхээр заасан. Нийт 191 байгууллагаас 7 нь хугацаандаа мэдээлж, 23 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 147 нь

¹ төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

² хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани

хамааралгүй байна. Худалдан авах ажиллагааны тайлангаа 14 байгууллага мэдээлээгүй. Тухайлбал:

Улсын төсвийн байгууллага

- АШУИС;
- Онцгой байдлын газар;
- ХХҮГ;
- Цагдаагийн газар;
- Эрүүл мэндийн газар.

ОН, ТЗШ-ийн байгууллага

- Эрдэнэ сумын ТТЗ, ЕБС;
- Замын-Үүд ТТЗ;
- Замын-Үүд Хүүхдийн 5-р цэцэрлэг;
- Сайншанд ЕБ-ын 1, 3-р сургууль;
- Сайншанд ЕБ-ын 4, 5-р сургууль;
- Сайншанд Хүүхдийн 11-р цэцэрлэг.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг 01 дүгээр сарын 10-ны дотор мэдээлэх нийт 191 байгууллагын 4 нь хугацаандаа мэдээлж, 7 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 176 нь хамааралгүй байна. Мэдээллийг 73 хувь нь байршуулж, 4 байгууллага буюу 27 хувь нь мэдээлээгүй. Тухайлбал:

Орон нутгийн байгууллага

- Айраг сумын ТТЗ;
- Дэлгэрэх сумын ТТЗ;
- Хөвсгөл сумын ТТЗ;
- Эрдэнэ сумын ТТЗ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор мэдээлэх нийт 3056 мэдээллийн 2591 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 322 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээллийн 95 хувийг байршуулж, 143 мэдээлэл буюу 5 хувийг мэдээлээгүй байна.

Улсын төсвийн байгууллага


- Нийгмийн даатгалын сан 5;
- Замын-Үүд эмнэлэг 2;
- Шүүхийн шинжилгээний алба 2.

ОН, ТЗШ-ийн байгууллага

- Алтанширээ сумын ТТЗ 5
- Алтанширээ сумын ИТХ 10;
- Алтанширээ сумын ЗДТГ 10;
- Хөвсгөл сумын ЕБС 3;
- Хөвсгөл Хүүхдийн цэцэрлэг 3;
- Хөвсгөл Соёлын төв 3;
- Сайншанд сумын ИТХ 3.


Төсвийн гүйцэтгэлийн 1-12 сарын мэдээг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Зураг №1




Биеийн тамир, спортын газар

Зураг №22



Дэлгэрэх сумын ТТЗ

Зураг №3



Замын-Үүд сумын ТТЗ

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасан дараа жилийн төсвийн төслийг 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэх нийт 191 байгууллагын 127 нь хугацаандаа мэдээлж, 43 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 7 нь хамааралгүй байна. Мэдээллийг 92 хувь нь байршуулж, 14 байгууллага буюу 8 хувь нь мэдээлээгүй. Тухайлбал:

Улсын төсвийн байгууллага

- Мал эмнэлгийн газар;
- Татварын хэлтэс;
- Шүүхийн шинжилгээний алба;
- Авто тээврийн үндэсний төвийн Замын-Үүд салбар.

ОН, ТЗШ-ийн байгууллага

- Дэлгэрэх сумын ТТЗ, ЭМТ;
- Мандах сумын ТТЗ;
- Сайхандулаан сумын ТТЗ;
- Хөвсгөл сумын ТТЗ, ИТХ;
- Эрдэнэ сумын ТТЗ, ЭМТ;
- Сайншанд сумын ЗДТГ;
- Зүүнбаян БТСТ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан хагас жилийн санхүүгийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэх нийт 191 байгууллагын 136 нь хугацаандаа мэдээлж, 35 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 8 нь хамааралгүй байна. Мэдээллийг 93 хувь нь байршуулж, 12 байгууллага буюу 7 хувь нь мэдээлээгүй. Тухайлбал:

Улсын төсвийн байгууллага

- Мал эмнэлгийн газар;
- Статистикийн хэлтэс;
- Цагдаагийн газар.

ОН, ТЗШ-ийн байгууллага

- Дэлгэрэх сумын ТТЗ, ИТХ, ЗДТГ;
- Дэлгэрэх сумын ЭМТ;
- Хөвсгөл сумын ТТЗ;
- Зүүнбаян ЗДАА, БТСТ, Цэцэрлэг;
- Эрдэнэ сумын ЭМТ;

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-т заасан аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэх нийт 191 байгууллагын 165 нь хугацаандаа мэдээлж, 10 нь хугацаа хоцроож мэдээлсэн, 7 нь хамааралгүй байна. Мэдээллийг 95 хувь нь байршуулж, 9 байгууллага буюу 5 хувь нь мэдээлээгүй. Тухайлбал:

ТӨААТҮГ, УТ-ийн байгууллага


- Мал эмнэлгийн газар;
- Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ.

ОН, ОНӨ, ТЗШ-ийн байгууллага


- БОАЖГ;
- Дэлгэрэх сумын ЗДТГ, Соёлын төв;
- Сайхандулаан сумын ЗДТГ;
- Халамжийн сан;
- “Тохижилт-Сайншанд” ХТГ;
- Чандманьбадрал ОНӨХХК.

Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг 1 pdf болголгүйгээр хуудас тус бүрээр 1 бүрчлэн оруулсан байна. Энэ нь хуулийн 4.1.2-д заасан мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх гэсэн шаардлагыг хангаагүй байна.

Зураг №4



Зураг №5



Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасан аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлэх нийт 191 байгууллагын 116 нь хугацаандаа мэдээлж, 37 нь хугацаа хоцроож мэдээлсэн. Мэдээллийг 80 хувь нь байршуулж, 38 байгууллага буюу 20 хувь нь мэдээлээгүй. Тухайлбал:

ТӨААТҮГ, УТ-ийн байгууллага

- Мал эмнэлгийн газар;
- Нийгмийн даатгалын хэлтэс;
- УАҮРСТ;
- Халзан-Уул РСТ;
- ХЭДС;
- ШШГГ;
- Шүүхийн шинжилгээний алба;
- Эрүүл мэндийн газар.
- Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ.

ОН, ОНӨ, ТЗШ-ийн байгууллага

- Айраг сумын ТТЗ, ЗДТГ, ИТХ;
- Алтанширээ сумын ИТХ, ЗДТГ;
- Даланжаргалан сумын ТТЗ;
- Дэлгэрэх сумын ИТХ, ЗДТГ, ЕБС;
- Иххэт сумын ИТХ, ЭМТ;
- Өргөн сумын ТТЗ;
- Сайхандулаан сумын ИТХ, ЗДТГ;
- Улаанбадрах сумын Соёлын төв;
- Хөвсгөл сумын ТТЗ, ЕБС;
- Замын-Үүд сумын ТТЗ;
- Замын-Үүд Хүүхдийн 1, 4-р цэцэрлэг;
- Зүүнбаян БТСТ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан төсвийн хэмнэлт хэтрэлтийн шалтгаан тайлбарыг улирал бүр мэдээлэх нийт 756 мэдээллийн 198 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна. Мэдээллийн 26 хувийг мэдээлж, 558 мэдээлэл буюу 74 хувийг мэдээлээгүй байна.

Байгууллагууд төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгаан тайлбарыг мэдээлж хэвшээгүй байна. Тухайн зөрчил нь нийт мэдээлээгүй мэдээллийн 20 хувийг эзэлж байна.

Дээрх зөрчлүүд нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн байна.

1.1.2 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлэхгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр мэдээлэх нийт 191 байгууллагын 174 нь

хугацаандаа мэдээлж, 3 нь хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээллийг 93 хувь нь байршуулж, 14 байгууллага буюу 7 хувь нь мэдээлээгүй. Тухайлбал:

<u>ОН, ТЗШ-ийн байгууллагууд</u>	
- Дорноговь аймгийн ТЕЗ;	- Өргөн сумын Соёлын төв;
- Алтанширээ сумын ЗДТГ;	- Хатанбулаг сумын ТТЗ;
- Иххэт сумын ЗДТГ;	- Хатанбулаг сумын ЭМТ;
- Иххэт сумын ЭМТ;	- Хөвсгөл сумын ЕБС;
- Мандах сумын ТТЗ;	- Хөвсгөл Хүүхдийн цэцэрлэг;
- Өргөн сумын ЭМТ;	- Хөвсгөл сумын ЭМТ;
	- Замын-Үүд сумын ТТЗ;
	- Зүүнбаян БТСТ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д заасан тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдээлэх нийт 191 байгууллагын 30 нь хугацаандаа мэдээлсэн, 159 нь хамааралгүй байна. Мэдээллийг 94 хувь нь байршуулж, 2 байгууллага буюу 6 хувь нь мэдээлээгүй. Тухайлбал:

ОНӨ, ТЗШ-ийн байгууллагууд

- Зүүнбаян БТСТ;
- Нийтлэг үйлчилгээний газар.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т заасан тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгааныг мэдээлэх нийт 307 мэдээллийн 236 мэдээлэл буюу 77 хувийг мэдээлж, 71 мэдээлэл буюу 23 хувийг мэдээлээгүй байна. Тухайлбал:

<u>ТӨААТҮГ, УТ-ийн байгууллага</u>	<u>ОН, ОНӨ, ТЗШ-ийн байгууллага</u>
- Замын-Үүд Цагдаагийн хэлтэс – 1;	- ГХБХБГ – 3;
- Замын-Үүд ШШГХ – 1;	- Алтанширээ сумын ТТЗ – 4;
- Нэгдсэн эмнэлэг – 5;	- Иххэт сумын ЕБС – 2;
- Онцгой байдлын газар – 4;	- Хөвсгөл сумын ТТЗ – 6;
- Прокурорын газар – 1;	- Эрдэнэ сумын ТТЗ – 3;
- ХХҮГ – 1;	- Замын-Үүд ЕБ-ын 1-р сургууль – 3;
- Эрүүл мэндийн газар – 5;	- Сайншанд ЕБ-ын 1-р сургууль – 7;
- Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ – 1.	- Сайншанд ЕБ-ын 4-р сургууль – 4;
	- Чандмань бадрал ОНӨХХК – 2.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг мэдээлэх нийт 543 мэдээллийн 416 мэдээлэл буюу 77 хувийг мэдээлж, 127 мэдээлэл буюу 23 хувийг мэдээлээгүй байна. Тухайлбал:

<u>Улсын төсвийн байгууллага</u>	
- АШУИС 2 гүйлгээ;	- Эрүүл мэндийн газар 3 гүйлгээ.
- Мал эмнэлгийн газар 4 гүйлгээ;	<u>ОН, ТЗШ-ийн байгууллага</u>
- ХХҮГ 2 гүйлгээ;	- Дорноговь аймгийн ЗДТГ 6 гүйлгээ;

- Алтанширээ сумын ТТЗ 7 гүйлгээ;
- Хатанбулаг сумын ТТЗ 4 гүйлгээ;
- Хөвсгөл сумын ТТЗ 8 гүйлгээ;
- Эрдэнэ сумын ТТЗ 7 гүйлгээ’
- Сайншанд ЕБ-ын 1-р сургууль 8 гүйлгээ;

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 3615 мэдээллийн 3380 мэдээллийг мэдээлж, 235 мэдээллийг мэдээлээгүй байна. Тухайлбал:

ТӨААТҮГ, УТ-ийн байгууллага

- Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ 7 гүйлгээ.

ОН, ТЗШ-ийн байгууллага

- Мал эмнэлгийн газар 4 гүйлгээ
- ХЭДС 7 гүйлгээ;
- БТСГ 14 гүйлгээ;
- БСУГ 9 гүйлгээ;
- Дэлгэрэх сумын ЗДТГ 4 гүйлгээ;
- Чандмань-Илч ХХК 30 гүйлгээ;
- Халамжийн сан 62 гүйлгээ

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 1999 мэдээллийн 1580 мэдээлэл буюу 79 хувийг мэдээлж, 419 мэдээлэл буюу 21 хувийг мэдээлээгүй байна. Тухайлбал:

УТ-ийн байгууллага

- БСУГ 21 гүйлгээ;
- Мал эмнэлгийн газар 4 гүйлгээ;
- СШ Гаалийн газар 4 гүйлгээ;
- ХЭДС 37 гүйлгээ;
- ХХААГ 7 гүйлгээ.

ОН, ТЗШ-ийн байгууллага

- ГХБХБГ 10 гүйлгээ;
- Сайншанд сумын ЗДТГ 7 гүйлгээ;
- Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургууль 11 гүйлгээ;
- Замын-Үүд Соёл спортын ордон 12 гүйлгээ;
- Халамжийн сан 20 гүйлгээ;
- “Тохижилт Сайншанд” ХТГ 28 гүйлгээ;
- Чандмань-Илч ХХК 31 гүйлгээ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6-д заасан худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг нийт 191 байгууллагын 36 нь мэдээлж, 144 нь хамааралгүй байна. Мэдээллийг 77 хувь нь мэдээлж, 11 байгууллага буюу 23 хувь нь мэдээлээгүй байна. Тухайлбал:

Улсын төсвийн байгууллага

- Нэгдсэн эмнэлэг.

ОН, ТЗШ-ийн байгууллага

- МСҮТ;
- Алтанширээ сумын ТТЗ;
- Даланжаргалан сумын ТТЗ;
- Дэлгэрэх сумын ТТЗ;
- Өргөн сумын ЭМТ;
- Сайхандулаан сумын ТТЗ;
- Улаанбадрах сумын ТТЗ;
- Хөвсгөл сумын ТТЗ;
- Эрдэнэ сумын ТТЗ;
- Зүүнбаян БТСТ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг нийт 191 байгууллагын 149 нь мэдээлж, 41 нь хамааралгүй байна. Зүүнбаян БТСТ мэдээлээгүй байна.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэр мэдээлэх нийт 4755 мэдээллийн 3738 мэдээлэл буюу 79 хувийг мэдээлж, 1017 мэдээлэл буюу 21 хувийг мэдээлээгүй байна.

Тушаал, шийдвэр мэдээлээгүй зарим байгууллагыг дурдвал:

<u>Улсын төсвийн байгууллага</u>	<u>ОН, ТЗШ-ийн байгууллага</u>
- АШУИС 18 тушаал; - Нийгмийн даатгалын хэлтэс 11 тушаал; - Мал эмнэлгийн газар 34 тушаал; - Нэгдсэн эмнэлэг 18 тушаал; - ХХҮГ 11 тушаал; - Цагдаагийн газар 10 тушаал; - Эрүүл мэндийн газар 20 тушаал.	- Дорноговь аймгийн ТЕЗ 33 захирамж; - Даланжаргалан ТТЗ 22 захирамж; - Дэлгэрэх сумын ИТХ 26 тушаал; - Дэлгэрэх сумын ЭМТ 22 тушаал; - Замын-Үүд сумын ТТЗ 22 захирамж; - Сайхандулаан сумын ИТХ 37 тушаал шийдвэр - Эрдэнэ сумын ЭМТ 29 тушаал - Сайншанд сумын ТТЗ 35 захирамж; - Сайншанд сумын ИТХ 21 тушаал
- Хөвсгөл сумын ТТЗ, Хөвсгөл сумын ЗДТГ, АШУУИС тушаал, шийдвэрийг шилэн дансанд мэдээлэхдээ pdf файлаар оруулаагүй.	
- Халзан-Уул рашаан сувиллын төв тушаал шийдвэрийг 1-11 сар хүртэл мэдээлэлгүй, 12 дугаар сард нийтэд нь мэдээлсэн.	
- Даланжаргалан сумын ЕБС, Даланжаргалан сумын Соёлын төв тушаал шийдвэрийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл хэсэгт мэдээлсэн.	


Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр 1031 мэдээлэл буюу нийт мэдээлээгүй тооны 37 хувийг эзэлж байна.

Энэ нь олон нийтэд зөрүүтэй, дутуу мэдээлэл хүрэх, ил тод байдал бүрэн хангагдахгүй байх нөхцөл үүсэж, Шилэн дансны тухай хуулийн зорилт бүрэн хангагдахгүй байх, хэрэгжилтийн ач холбогдлыг бууруулах үр дагавартай байна.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015 оноос эхлэн жил бүр нийцлийн аудитыг гүйцэтгэж байна. Тайлант оны мэдээллийг өмнөх оны мэдээлэлтэй харьцуулахад дараах үзүүлэлттэй байна.

Сүүлийн 2 жилийн байдлаарх тоон үзүүлэлт, харьцуулалт

График №1



Графикаас харахад 2019 онд мэдээлээгүй тоо өмнөх оноос 58 хувиар өссөн байна.

Дээрх графикт:

- Тайлант он болон өмнөх оны судалгааны тоон мэдээллийг шинжлэхдээ харьцуулагдахуйц 45 үзүүлэлтийг сонгон авч, 177 байгууллагыг хамруулав.
- 2019 онд Замын-Үүд сумын Соёл, спортын ордон, 6 дугаар цэцэрлэг, Сайншанд сумын 13 дугаар цэцэрлэг, Мал эмнэлгийн газрууд шинээр байгуулагдсан байна. Эдгээр байгууллагуудын байршуулаагүй 84 мэдээллийг тайлант оны үзүүлэлтэд хамруулсан болно.

Сүүлийн 3 жилийн байдлаар зөрчлийг удаа дараа давтан гаргаж байгаа байгууллагууд

Хүснэгт №1

Д/д	Байгууллагын нэр	Байршуулаагүй мэдээллийн тоо		
		2017 он	2018 он	2019 он
1	Дэлгэрэх сумын ЗДТГ	20	20	20
2	Сайхандулаан сумын ИТХ	14	27	39
3	Замын-Үүд сумын Чандмань бадрал ОНӨХХК	6	108	27
4	Сайншанд сумын ЗДТГ	9	13	29
5	Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургууль	23	2	50
6	Дорноговь аймгийн ТЕЗ	19	9	43
7	Дэлгэрэх сумын ТТЗ	23	33	52
8	Сайхандулаан сумын ТТЗ	22	27	24
9	Сайншанд сумын ТТЗ	7	144	57

Хуульд заасан хугацаанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээлэхгүй байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Зарим байгууллага, албан тушаалтан шилэн дансны цахим хуудасны өөрийн байгууллагад хамааралтай мэдээллийг мэдээлдээгүй. Тухайлбал: Мал эмнэлгийн газар жилийн эцэст оруулдаг мэдээллийг мэдээгүйн улмаас орхигдуулсан гэсэн тайлбарыг ирүүлсэн.
- Мэдээлэл байршуулах эрх бүхий албан тушаалтан удаа дараа солигдсон. Тухайлбал: Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуульд 2019 онд 5 нягтлан бодогч солигдож тогтвор суурьшилгүй ажилласан байна.
- Мэдээллийг дутуу оруулах, хугацаа хоцроосон мэдээллийг нөхөж оруулж байгаа нь нягтлан бодогч өвчтэй, чөлөөтэй үед түүний үүргийг түр гүйцэтгэх албан хаагчийг томилохгүй байгаатай холбоотой байна. Тухайлбал: Халамжийн сан, Эрүүл мэндийн

газрын нягтлан бодогч удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байсантай холбоотой байна.

- Тогтсон хугацаанд болон 7 хоногийн дотор байршуулах мэдээллийг нягтлан бодогч нар сүүлийн өдөр мэдээлдгээс цахим хаягт олон хэрэглэгч хандаж сүлжээний доголдол үүсдэг байна.

Цаашид төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний эд хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан хугацаа хоцорсон болон байршуулаагүй мэдээллийг журамд заасан хугацаанд мэдээлж байх шаардлагатай байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 болон 6.4.8-д заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй дээрх алдаа, зөрчлийг арилгуулах тухай албан шаардлагыг аймгийн СТСХ-ийн холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

1.2 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд самбарын мэдээллийг бүрэн байршуулах шаардлагатай байна.


1.2.1 Байгууллагууд шилэн дансны мэдээллийг санхүүгийн мэдээллийн самбарт бүрэн мэдээлэхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд “байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх, мөн орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасан.

Цар тахалтай холбоотойгоор аудитаар сумдад ажиллах боломжгүй байсан тул шилэн дансны мэдээллийг мэдээллийн самбараар дамжуулан хүргэсэн эсэхийг бүх байгууллагыг хамруулан шалгах боломжгүй байв. Тиймээс зөвхөн Сайншанд суманд байрлах орон нутгийн өмчит байгууллагуудаас түүвэрлэн аймгийн ТЕЗ-ийн харьяа 35 байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлж байгаа эсэхийг тулган шалгалаа. Бүрэн мэдээлсэн 17 байгууллага, дутуу мэдээлсэн 15 байгууллага байна.

Санхүүгийн мэдээллийн самбартай боловч мэдээллийг байршуулаагүй дараах 3 байгууллага байна. Үүнд:

Зураг №6



Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургууль

Зураг №7



Сайншанд сумын Хүүхдийн 8 дугаар цэцэрлэг

Зураг №8



Сайншанд сумын Хүүхдийн 10 дугаар цэцэрлэг

Шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлүүдийг дурдвал:

- Мэдээллийн самбарт мэдээлж байгаа мэдээлэл нь ихэвчлэн батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэл байгаа бөгөөд худалдан авалтын төлөвлөгөө, тендерийн

талаарх мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлсэн байгууллага харьцангуй бага байна.

- *Зарим байгууллагын мэдээллийн самбарт санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт мэдээлэх цэс байхгүй.*
- *Мэдээллийг шинэчлээгүй.*

Мөн мэдээллийн агуулгыг иргэд олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх хэрэгтэй байна.

1.2.2 Зарим байгууллага мэдээллийн самбарыг олон нийт чөлөөтэй танилцах боломжтой газар байрлуулах шаардлагатай байна.

Хуулийн 5.8-д зааснаар мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан мэдээллүүдийг самбартаа байршуулан мэдээлсэн байна.

Чандмань-Илч ОНӨХХК, Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, Сайншанд сумын 8 дугаар цэцэрлэг нягтлан бодогчийн өрөөнд, Сайншанд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нярвын өрөөнд байрлуулсан.

Энэ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хандалт хийх боломжгүй иргэдийн тухайн байгууллагын шилэн дансны мэдээлэлтэй танилцах, хяналт тавих боломжийг хязгаарласан ба Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8³, Мэдээллийн ил, тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁴ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

³ Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

⁴ Энэ хуулийн 3.1-д заасан байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдалтай холбогдсон харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна.

БҮЛЭГ 2. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭЛД ХАМААРАХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД ХУУЛИЙГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БА ҮҮНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.

2.1 Хуулийн 3.1.3-т хамаарах байгууллага хуульд заасан мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн мэдээлээгүй байна.

2.1.1 Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Дорноговь аймагт Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр эзэмшдэг “Дорноговь АЗЗА” ТӨХК үйл ажиллагаа явуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д заасан байгууллага тус хуулийн 6.8.1-6.8.3-т заасан мэдээллийг байгууллагын нэгдсэн систем дэх цахим хуудсанд мэдээлэхээр зааснаас 6.8.1⁵, 6.8.3⁶ дахь заалтууд тус байгууллагад хамаарахгүй байна.

Харин хуулийн 6.8.2-т заасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, тайланг 1 дүгээр сарын 15-ны дотор, тендерийн ерөнхий мэдээллийг 7 хоногийн дотор тус тус мэдээлэхээр журамласан байна.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 онд шилэн дансны нэгдсэн системд хуульд заасан мэдээллийг мэдээлсэн байдал

/Хүснэгт №2/

№	Мэдээлэх мэдээллийн нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн байдал		
			мэдээлсэн	хугацаа хоцроосон	мэдээлээгүй
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	1		1	
2	Худалдан авах ажиллагааны тайлан	1			1
3	Тендер, худалдан авалтын ерөнхий мэдээлэл	1	1		

Дорноговь АЗЗА ТӨХК нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна.

2.1.2 Шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д хамаарах байгууллага нь төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс 7 хоногийн дотор мэдээлэхээр журамласан байна.



Дорноговь АЗЗА ТӨХК нь 2019 онд төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 17 тушаал шийдвэр гаргасан боловч, үүнээс 6 тушаал буюу 35 хувийг мэдээлж, 11 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.

Мөн тус байгууллагын 2019 оны шилэн дансны цахим хуудасны хөтлөлтийг авч үзэхэд тендерийн ерөнхий мэдээлэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан мэдэгдэл, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах тухай

⁵ тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр;

⁶ төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт.

тушаал, шийдвэр, их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа зэрэг мэдээллийг 2, 4, 6-8 болон 12 сард хугацаа хоцроож мэдээлсэн байна. /Зураг №1-2/



Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны шилэн дансны эрхлэн хөтлөлтийн байдал

2.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд хууль, журамд заасан мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.2.1 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т заасан ААНБ-дын 4 хувь нь шилэн дансны цахим хуудаст мэдээлэх эрх нээлгэсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д заасны дагуу 2019 онд 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 53,699.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 199 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 159 ААНБ-тай гэрээ байгуулан ажилласан байна. /Хүснэгт /

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний судалгаа


/Хүснэгт №3/

№	Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	41	38,934.8
2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	48	6,585.9
3	Замын-Үүд сумын хөрөнгө оруулалт	13	1,316.0
4	Замын сангийн хөрөнгө оруулалт	6	410.2
5	Орон нутгийн хөгжлийн сан	90	6,452.8
Нийт		199	53,699.7


Дээрх улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэгчээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст “Төгс хурц консалтинг ХХК”, “Алтайн газрын хүч ХХК”, “УАЗ мега ХХК”, “Эм ти эм жи ХХК”, “Баялаг говь ХХК”, “Мед буян ХХК”, “Эс жи эм ХХК” гэсэн 7 ААНБ мэдээлэх эрхийг нээлгэсэн байна. /Зураг №/

Тухайлбал:


Зураг №11



Зураг №12



Зураг №13



Харин шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 152 ААНБ мэдээлэх эрх нээлгээгүй байна.

Эрх нээлгээгүй зарим байгууллагуудын удирдлага, албан тушаалтнаас асуулга авч, тодруулахад “Шилэн дансны тухай хууль”-ийн талаар мэдлэггүй, ямар мэдээллийг хэрхэн мэдээлж байх талаар мэдээлэлгүй байна гэсэн тайлбарыг өгч байна. /

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх эрхийг хэрхэн нээлгэх талаар хууль болон холбогдох журамд тодорхой заагаагүй байна.


2.2.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд холбогдох хууль, журамд заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын⁷ 1.2⁸ болон 5.1 дэх хэсэгт “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэн гүйцэтгэх ажлын нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, санхүүжилтийн талаарх мэдээллийг улирал бүр дараа сарын 15-ны дотор мэдээлнэ” гэж журамласан байна.


Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7 ААНБ мэдээлэх эрх нээлгэсэн боловч тайлант онд цахим хуудсыг эрхлэн хөтлөөгүй, холбогдох мэдээллийг мэдээлээгүй байна. /Зураг №/

Тухайлбал:


Зураг №14



Зураг №15



Зураг №16



⁷ Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам

⁸ Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч (цаашид “байгууллага” гэх) нь шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй.

Энэ нь Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 1.2-т заасныг зөрчсөн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй” гэж заасан байна.

Гэтэл ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд нь төсвийн байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нэвтрэх эрхгүй, мэдээлэл байршуулах боломж нөхцөл бүрдээгүй ба энэ нь хууль, журмаар тодорхой зохицуулагдаагүй байна.


Харин төсвийн байгууллага өөрийн цахим хуудсаар хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийн талаар мэдээлж байна.

Энэ талаар төсвийн байгууллагын зарим албан тушаалтан, холбогдох мэргэжилтнээс тодруулахад хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэгч хувийн ААНБ-ууд төсвийн байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нэвтрэх эрх байдаггүй, зөвхөн төсвийн байгууллагын зүгээс мэдээллийг заасан хугацаанд мэдээлдэг, ажлын явц санхүүжилтийг худалдан авах ажиллагааны тайланд тусгаж цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлдэг гэсэн тайлбарыг өгч байна.


Мөн дээрх ААНБ-ууд нь хуульд заасан мэдээллийг бусад мэдээллийн цахим хуудсаар мэдээлсэн эсэхийг шалгахад мэдээлэл байршуулах тодорхой цахим хуудасгүй, өөрийн цахим мэдээллийн сайт, Facebook хуудастай боловч мэдээлээгүй байна. /Зураг №/

Тухайлбал:


Зураг №17




Зураг №18




Зураг №19




Зураг №20



Зураг №21



Зураг №22



Иймд дээрх улс, орон нутгийн төсвөөс санхүүжилт авч хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-д мэдээлэл байршуулах цахим хуудас, цэс нээх, захиалагч байгууллага хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар гүйцэтгэгч байгууллагатай байгуулах гэрээнд тусгах, гэрээг дүгнэх үзүүлэлтэд оруулах зэрэг арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Мөн Шилэн дансны тухай хууль болон журамд ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд хуульд заасан мэдээллийг хэрхэн мэдээлэх талаар тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.

2.3 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч ААНБ нь мэдээлэх эрхээ нээлгэсэн ч зарим байгууллага хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.


2.3.1 Хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуульд заасан мэдээллийг мэдээлэх эрхийг бүрэн нээлгэсэн байна.

Дорноговь аймагт Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д хамаарах хувийн 1 ерөнхий боловсролын сургууль, 4 цэцэрлэг, 4 өрхийн эрхийн мэндийн төв, нийт 9 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага улс, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор цахимаар мэдээлэхээр заасан байна.

Хуулийн 3.1.5-д хамаарах 9 ААНБ-д тайлант онд ерөнхий боловсрол олгох, сургуулийн өмнөх боловсрол олгох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд улс, орон нутгийн төсвөөс нийт 1206.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. /Дүрслэл №/. Эдгээр байгууллагаас ӨЭМТ-үүд сумын Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газартай гуравласан гэрээг байгуулж, аймгийн Засаг дарга баталгаажуулан, жилийн эцэст гэрээг дүгнэсэн байна. Харин бусад байгууллага гэрээ байгуулаагүй, улсын төсвөөс суралцагчдын хувьсах зардлын санхүүжилтийг олгосон байна.

Дүрслэл №1



Мөн дээрх 9 байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хууль, журамд заасан мэдээллийг мэдээлэх эрхийг бүгд нээлгэсэн байна.

2.3.2 Зарим байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг огт эрхлэн хөтлөөгүй, санхүүжилтийн талаар мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй” гэж заасан байна.

Тайлант онд хуулийн 3.1.5-д хамаарах ААНБ-ын шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг мэдээлсэн эсэхийг үзэхэд дараах байдалтай байна.


Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл мэдээлсэн байдал

/Хүснэгт №4/


№	Ажил гүйцэтгэгч аж ахуй нэгжийн нэр	Санхүүжилт		Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байдал			
		Нийт төсөвт өртөг /сая.төг/	Санхүүжилт өссөн дүнгээр /сая.төг/	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1	Жаргалан цэцэрлэг	98.4	98.4	тийм	тийм	тийм	тийм
2	Болор-Эрдэнэ цэцэрлэг	82.1	82.1	тийм	тийм	тийм	тийм
3	Үлэмж тэнгэр сургууль	121.2	121.2	үгүй	үгүй	үгүй	үгүй
4	Ухаалаг багачууд цэцэрлэг	80.2	80.2	үгүй	үгүй	үгүй	үгүй
5	Гурван билэг цэцэрлэг	34.4	34.4	тийм	тийм	тийм	тийм
6	Агатова ӨЭМТ	150.7	146.4	тийм	тийм	тийм	тийм
7	Мишээлт мана ӨЭМТ	223.6	220.1	тийм	тийм	тийм	тийм
8	Талст зам ӨЭМТ	111.5	113.6	тийм	тийм	тийм	тийм
9	Борхойн наран ӨЭМТ	310.2	310.2	тийм	тийм	тийм	тийм
Нийт дүн		1,212.3	1,206.6				

Дээрх хүснэгтээс харахад Замын-Үүд сумын “Үлэмж тэнгэр” ЕБС, “Ухаалаг багачууд” цэцэрлэг шилэн дансны цахим хуудсыг эрхлэн хөтлөөгүй, улирал бүр мэдээлэх мэдээллийг байршуулаагүй байна. /Зураг №/

Зураг №23



Зураг №24



Энэ талаар холбогдох албан тушаалтнаас тодруулахад “Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тендер худалдан авах ажиллагаа гэсэн цэс нээгдсэн байдаг учир санхүүжилтийн мэдээллийг оруулаагүй, өмнөх нягтлан бодогч нэвтрэх нэр, нууц үгийг мартсан шалтгаанаар өгөөгүй” гэсэн тайлбаруудыг өгч байна.

Мөн “Жаргалан” цэцэрлэг 4 дүгээр улирлын, “Болор-Эрдэнэ” цэцэрлэг 2 дугаар улирлын, “Гурван билэг” цэцэрлэг 2 болон 4 дүгээр улирлын санхүүжилтийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлд тус хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг зөвхөн Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын арга хэмжээ авахаар тусгасан нь энэ хуулийн 3.1.3-3.1.5-д хамаарах байгууллагуудад хэрэгжүүлэх боломжгүй, хэрхэн хариуцлага тооцох нь тодорхойгүй байна.

БҮЛЭГ 3. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНААС ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

3.1 Хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллагууд хяналт тавьж ажилласан боловч хангалтгүй байна.

3.1.1 Аймаг, сумдын ИТХ-аас хуульд заасан байгууллагыг бүрэн хамруулаагүй, хяналтыг чанаргүй хэрэгжүүлж байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1⁹-д заасны дагуу аймгийн ИТХ-аас сумдын ИТХ-д хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгах, хийсэн ажлын тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор ирүүлэх чиглэлийг өгсөн байна. Үүний дагуу зарим сумдын ИТХ-аас тухайн улирлын тайланг ирүүлсэн байна. /Хүснэгт №/

Сумдын ИТХ-аас АИТХ-д хуулийн хэрэгжилтэд хяналт хийсэн ажлын тайланг ирүүлсэн байдал.

/Хүснэгт №5/

№	Сумдын нэр	АИТХ-д шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийсэн ажлын тайлан /улирлаар/			
		I	II	III	IV
1	Айраг				1
2	Алтанширээ				
3	Даланжаргалан	1	1	1	1
4	Дэлгэрэх	1			
5	Иххэт	1	1	1	1
6	Мандах	1			1
7	Сайхандулаан				
8	Өргөн	1		1	1
9	Улаанбадрах	1	1		1
10	Хөвсгөл	1			
11	Хатанбулаг	1	1	1	1
12	Эрдэнэ	1			
13	Сайншанд				
14	Замын-Үүд				
15	Аймаг				
Дүн		9	4	4	7

Дээрх хүснэгтээс харахад Даланжаргалан, Иххэт, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдын ИТХ хяналтыг хэрэгжүүлж, тайланг аймгийн ИТХ-д ирүүлсэн байна. Харин Алтанширээ, Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан сумдын ИТХ хяналтыг хэрэгжүүлсэн талаарх мэдээ тайланг ирүүлээгүй байна. Сумдаас АИТХ-д жилд 56 ажлын тайланг хүргүүлэхээс 43.0 хувь буюу 24 тайлан ирүүлжээ. Хийсэн ажлын тайланг ирүүлээгүй сумдын ИТХ-аас хяналтыг хэрэгжүүлж ажилласан эсэхийг нотлох боломжгүй байна. Мөн сумдын ИТХ нь хяналт тавих ажлыг ИТХ дахь санхүү, эдийн засаг, төсвийн бодлогын хороодод хариуцуулсан боловч хэрэгжилтийг тооцоогүй байна.

Аудитын явцад аймгийн ИТХ болон 12 сумын ИТХ-аас хөндлөнгийн хяналт хийсэн тайланг ирүүлсэн бөгөөд Сайншанд, Замын-үүд сум тайлан ирүүлээгүй байна.

⁹ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал.....хэрэгжүүлнэ

Үүний шалтгааныг тодруулахад Сайншанд сумын ИТХ-аас шилэн дансны тухай хуулийг бүрэн судлаагүй, хуулиар хүлээсэн үүргээ мэдэхгүй, Замын-үүд сумын ИТХ-аас ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалан хяналтыг хэрэгжүүлээгүй гэсэн тайлбарыг тус тус өгч байна.

Сумдаас ирүүлсэн ажлын тайлангаас үзэхэд хяналт шалгалтаар шилэн дансанд үндсэн мэдээллээ шинэчлээгүй, мэдээллийг дутуу байршуулсан, төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг бичээгүй, оруулсан мэдээллийн үсгийн фонт танигдахгүй, мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээллийг огт байршуулаагүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Мөн сумдын ИТХ хуулийн хэрэгжилтийг хуульд заасан шалгуур буюу мэдээлбэл зохих бүх мэдээллийг байршуулсан эсэхийг хянаагүй, сум тус бүр харилцан адилгүй үзүүлэлт, шалгуураар хяналтыг хэрэгжүүлж байгаагаас илрүүлэлт хангалтгүй байна. Тухайлбал, байршуулбал зохих мэдээллийн тоог анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийн журнал зэрэгтэй тулгаж тогтоогоогүй. Мөн хяналт хэрэгжүүлсэн ихэнх сумдын ИТХ нь төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тусгайлсан үзүүлэлт болгон авч үзэлгүй, зөвхөн төсвийн гүйцэтгэлийн мэдээ байршуулсан байдлаар дүгнэсэн байна.

Шилэн дансны тухай хуульд бүх шатны ИТХ-аас энэ хуулийн үйлчлэлд хамаарах бүх байгууллагад хяналт тавих тухай заасан байтал зөвхөн хуулийн 3.1.1 буюу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж байна. Энэ нь хуульд заасан бусад байгууллагад тавих хяналт орхигдох, хуулийн хэрэгжилт бүрэн хэрэгжихгүй байх, мэдээллийн ил тод байдал хангагдахгүй зэрэг үр дагавартай байна.

Мөн түүнчлэн Шилэн дансны тухай хууль зөрчсөн албан тушаалтанд энэ хуулийн 10.1¹⁰-д заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр байгаа боловч аймаг, сумдын ИТХ-аас тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Харин АИТХ-аас сумдын ИТХ-ын ажлыг дүгнэхдээ “Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байдал”-ыг үзүүлэлт болгон арга хэмжээ авч ажилласан байна.

3.1.2 Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй байна.

Тайлант онд Шилэн дансны тухай хуулийн 8.2¹¹-д заасны дагуу Аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хуулийн 3.1.1-д хамаарах байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд хяналт шалгалт хийсэн байна. Хяналтыг 3 хоногийн хугацаатай зохион байгуулж, 2019 оны 11 сар хүртэлх хугацааг хамруулсан байна.

Шалгалтад нийт 147 байгууллага хамрагдсан байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 16280 мэдээллийг тухай бүр мэдээлэхээс 15072 мэдээлэл

¹⁰ Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

¹¹ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

буюу 92.5 хувийг хугацаанд нь, 1203 мэдээлэл буюу 7.4 хувийг хугацаа хоцроож, 5 мэдээлэл буюу 0.03 хувийг огт мэдээлээгүй зөрчил илэрсэн байна. Мөн эдгээр байгууллагууд шилэн дансны тайланг Сангийн яаманд мэдээллээ 100 хувь бүрэн илгээж, баталгаажуулсанд үндэслэн Шилэн дансны хуулийн хэрэгжилт тайлант хугацаанд хангалттай хэрэгжсэн гэж дүгнэсэн байна. Шалгалтаар зөрчилтэй гарсан 6 сумын 31 албан тушаалтанд сахилгын арга хэмжээ авах саналыг шат шатны удирдлагад хүргүүлж ажилласан байна. Гэвч одоогийн байдлаар хариуцлага тооцсон талаарх хариу мэдээлэл ирүүлээгүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтын тайлангаас харахад байршуулбал зохих мэдээлэл болон байршуулсан мэдээллийг харьцуулаагүй, зөвхөн нэгдсэн цахим системд байршуулсан мэдээлэлд үндэслэн хяналт шалгалтыг гүйцэтгэж, “баталгаажсан”, “хугацаа хоцроосон”, “мэдээлээгүй” гэсэн 3 үзүүлэлтээр дүгнэж гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг нарийвчлан зохицуулалтгүйгээс дотоод аудитын нэгж болон Төрийн аудитын байгууллага хяналт шалгалт хийх чиг үүргээ харилцан адилгүй хэрэгжүүлж байна.

Төрийн аудитын байгууллага болон Санхүүгийн хяналт, аудитын албаны илрүүлсэн зөрчлийн дүн зөрүүтэй байна. Тухайлбал, СХАА нь хуулийн 6.1.2-т заасан сар, улирлын төсвийн гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарыг нэг үзүүлэлтээр тооцсон бол Төрийн аудитын байгууллага төсвийн гүйцэтгэлийг сараар болон улирлаар мэдээлсэн эсэх, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг улирлаар гэж тус бүрээр нь нийт 20 үзүүлэлт болгон авч үзсэн.

Төрийн аудитын газраас төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг мэдээлсэн байдалд улирал тус бүрээр аудит хийхэд уг мэдээллийг 37-44 хувьтай байршуулсан байна. Гэтэл СХАА-ын шалгалтаар төсвийн гүйцэтгэл болон түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг нэгтгэн нэг үзүүлэлтээр шалгаж зөвхөн төсвийн гүйцэтгэлийн мэдээг байршуулсан тохиолдолд тухайн үзүүлэлтийг мэдээлснээр тайлагнасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.

3.2 Өмнө оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага бүрэн биелсэн байна.

3.2.1 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас өмнөх онд гүйцэтгэсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт аудитаар нийт 3 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл дараах байдалтай байна.
/Хүснэгт №/

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/Хүснэгт №6/

Байгууллага, албан тушаалтан	Аймгийн засаг дарга	Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс	Сайншанд сумын төвлөрүүлэн захирагч
Зөвлөмжийн утга	Энэ хуулийн 8.4 ¹² -т заасны дагуу сум, агентлагуудын ажлыг дүгнэхдээ хуулийн хэрэгжилтийг оруулж дүгнэж байх	“Улс, орон нутгийн төсвийн байгууллагуудын удирдах албан тушаалтан, нягтлан бодогч нарт ” Шилэн дансны тухай хууль”-ийг хэрэгжүүлж ажиллах, арга зүйн заавар зөвлөмжөөр хангах	Шилэн дансны нэгдсэн систем дэх цахим хуудсанд нэвтрэх албан тушаалтан, тэдгээрийн чиг үүргийг тодорхой болгож, мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж байх
Зөвлөмжийн хэрэгжилт	Агентлаг, сумдын ажлыг дүгнэхдээ “Байгууллагын чиг үүрэг” гэсэн хэсгийн 10 хувь байхаар тооцон ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан 2019 оны агентлаг, сумдын ажил дүгнэсэн байна.	2019 онд Санхүү төрийн сангийн хэлтсээс 2 удаа албан тоотоор чиглэл өгч, Замын-Үүд суманд зохион байгуулсан санхүү, төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогчдын сургалт, зөвлөгөөнд тус хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан байна.	Шилэн дансны нэгдсэн системийн мэдээллийг хариуцсан ажил үүргийн дагуу Төрийн сангийн дарга-12, Төрийн сангийн мэргэжилтэн-7, Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн-9, Сум хөгжүүлэх сангийн мэргэжилтэн-2 мэдээлэл оруулахаар хуваарилсан байна

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс зөвлөмжийг биелүүлсэн боловч алдаа, зөрчлийн тоо буурахгүй, давтагдан гарсаар байгаа нь хэрэгжүүлсэн арга хэмжээ нь үр дүн муутай байгааг харуулж байна.

3.2.2 Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2019 онд гүйцэтгэсэн аудитаар мэдээллийг нөхөн байршуулах тухай албан шаардлагыг 25 байгууллага, албан тушаалтанд өгсөн байна. Албан шаардлагад дурдсан зөрчлийг авч үзэхэд, 67.6 хувь буюу хуулийн 6.4.8¹³-д заасан мэдээллийг, 6.8 хувь нь 6.4.5¹⁴-д заасан мэдээллийг мэдээлээгүй, 25.6 хувь нь хугацаа хоцроон байршуулсан зөрчил байна.

Өмнөх оны аудитаар албан шаардлага хүргүүлсэн албан тушаалтнууд дараагийн аудитаар алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байгаа боловч, бусад байгууллагуудад зөрчил илэрсээр байна. Энэ нь шат шатны хяналт сул, хяналт хийхдээ мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдлыг шалгадаггүй, эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

¹² Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.

¹³ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

¹⁴ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

Мөн байгууллагын санхүүгийн ажилтан солигдох, байгууллагын удирдах ажилтны хяналт сул байгаа нь алдаа, зөрчил давтагдан гарах нэг шалтгаан болж байна.

Шилэн дансны тухай хуулиар хүлээлгэх хариуцлагыг энэ хуулийн 10.1-д Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ гэж заасан боловч Төрийн албаны тухай хуулийн дагуу хүлээлгэх хариуцлагыг зөвхөн төрийн жинхэнэ албан хаагчид хүлээлгэхээр байна. Харин шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулаагүй болон хугацаа хоцроон байршуулж байгаа ажилтнуудын ихэнх нь төрийн үйлчилгээний албан тушаалтан байх тул хуулийн дагуу хариуцлага тооцох боломжгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- 1) Аудитад хамрагдсан нийт 191 байгууллага Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан тогтмол мэдээлэх нийт 5730 мэдээллээс 3920 мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж, 605 мэдээллийг хугацаа хоцроож, 834 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
- 2) Хуулийн 6.4-т заасан 7 хоногийн дотор байршуулах мэдээллийг нийт байгууллагуудын 84 хувь нь мэдээлсэн байна.
- 3) Өмнөх онуудад илэрсэн зөрчил давтагдан гарч, зөрчлийн тоо буурахгүй байна.
- 4) Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 159 ААНБ төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч шилэн нэгдсэн цахим хуудаст эрх нээлгэсэн 7 байгууллага байна. Эдгээр байгууллагууд нь Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг байршуулаагүй, холбогдох хууль, журамд заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй байна.
- 5) Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ТАХ-г хэрэгжүүлсэн ААНБ-ууд нь холбогдох мэдээллийг хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудаст байрлуулахаар хуульчилсан боловч төсвийн байгууллагын шилэн дансны цахим хуудаст нэвтрэх эрхгүй, мэдээлэл байршуулах боломж нөхцөл бүрдээгүй байна.
- 6) Аймгийн ИТХ-аас сумдын ИТХ-д Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгах, хийсэн ажлын тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор ирүүлэх чиглэлийг өгч, хэрэгжүүлэн ажилласан байна.
- 7) Бүх шатны ИТХ нь Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах бүх байгууллагад хяналт тавихаар заасан байтал зөвхөн хуулийн 3.1.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хяналт хэрэгжүүлж байна.
- 8) СХАА болон бүх шатны ИТХ нь шилэн дансны мэдээлэлд хийх хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-3.1.5-д заасан нийт 400 байгууллага хамрагдаж, байршуулбал зохих 608 мэдээллийг хугацаа хоцроож, 3809 мэдээллийг мэдээлээгүй байна. Аудитаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

ЗӨВЛӨМЖ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т тус хуулийг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр хуульчилсан. Харин Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд хариуцлагын талаар тусгасан боловч энэ нь зөвхөн төрийн жинхэнэ албан хаагчид хамаарахаар заажээ. Гэтэл Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий албан тушаалтан нь улс төрийн, төрийн үйлчилгээний болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтан байна. Иймд уг хуулийн хариуцлагыг тодорхой тусгах талаар эрх бүхий байгууллагад уламжилж өгнө үү.

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.
Үүнд:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА С.ТҮМЭНБАЯР ТАНАА

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хуулийн 3.1-д хамаарах байгууллагыг бүрэн хамруулж, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах.
2. Сумдын ИТХ-д хуулийн хэрэгжилтэд хяналт тавих талаар тодорхой чиглэл өгч, хэрэгжилтийг тооцох аргазүйн зөвлөмж өгч ажиллах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Т.ЭНХТҮВШИН ТАНАА


1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ТАХ-г хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг цахим хуудаст байршуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.СОДХҮҮ ТАНАА

1. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын эрх бүхий албан тушаалтанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хуульд заасан хугацаанд байршуулаагүй байгаа зөрчлийг арилгахад чиглэсэн үр дүнтэй ажлыг зохион байгуулж, арга зүйгээр хангах.

**АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА Х.ОЮУНТУЯА ТАНАА**

1. Байршуулсан мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6.1 болон 6.4-т заасан шалгуур үзүүлэлт тус бүрээр хяналт хийж, хуулийн 6.4-т заасан мэдээллийг бүрэн байршуулсан эсэхэд тавих хяналтыг сайжруулах.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Утас: (705) 2-30-09, факс: (705) 2-31-40,
И-мэйл: dornogobi.ith@gmail.com

2020.05.13 № 140

танай 2020.05.11 -ны № 1-6/428 -т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хөндлөнгийн хяналт тавих бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлын чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах талаар жил бүр анхааран ажиллаж холбогдох тайланг хүргэсэн.

Танай байгууллагаас хийсэн аудитын тайланд өгөх санал байхгүй бөгөөд цаашид аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд сайтар анхааран ажиллах болно.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Н.ХОНГОРЗУЛ



448200195



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,
И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn, Вэбсайт: dornogovi.gov.mn

2020.05.13 № 3/809
танай 2020.05.11 -ны № 4-6/427 -т

**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
сэдэвт нийцлийн аудитын тайлантай холбоотой
саналгүй болно.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ





ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-00-25, (705) 2-00-26
И-мэйл: sankhuu_audit_dg@yahoo.com

2020.05.14 № 202
танай 2020.05.11 -ны № 1-6/429 -Т


ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.АРИУНАА ТАНАА



Хариу хүргүүлэх тухай

Таны ирүүлсэн 2020 оны 05 дүгээр сарын 11-ний өдрийн 1-6/429 тоот албан бичигтэй танилцлаа.

Монгол улсын Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.2-д заасны дагуу манай алба аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд дэх төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдалд улирал бүр хяналт тавьж ирсэн.

Хяналт шалгалтыг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу тухай бүр, сар бүр улирал бүр, хагас жил бүр, бүтэн жилээр тус тус оруулах мэдээллийг хуулийн хугацаанд мэдээллэсэн, хугацаа хожимдуулан мэдээллэсэн, огт мэдээллээгүй зэрэг байдалд шалгалтыг зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтыг гүйцэтгэх бүрдээ төсөвт байгууллага болон төрийн өмчид байгууллагын удирдлага болон шилэн данс хариуцсан албан тушаалтнуудад холбогдох заавар, зөвлөмжийг тухай бүр нь өгч ажиллаж байсан бөгөөд хяналтыг үр дүнгүй гүйцэтгэсэн гэж үзэхгүй байна.

ДАРГА  Х.ОЮУНТУЯА



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Аймгийн СХАА-ны 2020.05.14-ны 202 тоот албан бичгээр ирүүлсэн саналд:

Тайлангийн 3.1.2-т “хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлсэн боловч үр дүнгүй байна” гэж тусгасныг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтад нарийвчлан зохицуулалт байхгүй талаар тайланд нэмж тусган “Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй байна” гэж өөрчлөв.


АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Б.УРАНБИЛЭГ

У.ОЮУНТҮЛХҮҮР

Т.МӨНХТОГТОХ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ХЭРЛЭНЧИМЭГ

Ч.АРИУНАА

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/16

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаал, Ерөнхий аудиторов 2018 оны А/207 тоот тушаалын V хавсралтын 2.4, “Нийцлийн аудитын түр журам”-ын 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Санхүү хяналт, аудитын албанд тус тус зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Санхүү хяналт, аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.

5.Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т үүрэг болгосугай.


ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА



Дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны
05 дугаар сарын 15-ны өдрийн
.../16... тушаалын хавсралт



АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Хариуцагчийн		Албан шаардлагын	
		Албан тушаал	Овог, нэр	Дугаар	Товч утга
1	Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс	Дарга Ерөнхий санхүүч	Ц. Содхүү Х. Анхчимэг	01/99 ҮАГ-НАГ- 2020/01/-НА	Мэдээллийг нөхөн байршуулах тухай